



АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2019/01



www.nso.mn www.arkhangai.nso.mn www.1212.mn




ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 519 ор, амбулаторийн 99 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 26.7 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 8.2 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 2.0 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98.8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд 100.0 хувь хамруулсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 1 сарын байдлаар



Оны эхний 1 сард 132 эхээс 133 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 24 хувиар буюу 42 хүүхдээр бага байна,

Хүн амын нас баралт 42 гарсан нь өнгөрсөн оныхоос 1 тохиолдлоор буюу 2.4 хувиар их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 1.4, нас баралт 0.4 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 1 промил байна. Төрөхийн улмаас эндсэн эхийн эндэгдэл болон нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

1 гарч, нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 4 гарч мянган амьд төрөлтөд 30 ноогдож байна.



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 5 нь буюу 48 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 18.7 хувь нь салхин цэцгээр, 39.6 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 8.3 хувь нь сүрьеэгээр, 33.4 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс халдварт өвчний гаралт 11.6 хувиар буюу 5 тохиолдлоор өссөн байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР

2 дугаар сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 1231 ажилгүй хүн байгаагийн 47.9 хувь нь буюу 590 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10.0 мянган хүн тутамд 204 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2.8 хувиар багассан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 98.8 хувь нь боловсролтой иргэд

байгаагийн 173 нь дээд, 40 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 962 нь бүрэн болон бүрэн бус дунд, 42 нь бага боловсролтой хүмүүс байна.

1 дүгээр сард ажилгүйчүүдийн бүртгэлд 34 хүн шинээр бүртгүүлж, 140 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болсон байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 1 сард 8.1 тэрбум төг, зарлага 3.9 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 4270.9 сая төг буюу 110.1 хувиар, зарлага 564.3 сая төг буюу 16.8 хувиар тус тус өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 4270.9 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 111.6 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 145.6 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 120.3 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 76.1 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 16.8 хувиар өсөхөд даатгалын сангууд 16.3-195.5 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 3.9 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 135.6 сая төгрөгийг олгосон байна.

Оны эхний 1 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 26 мянган хүнд 2233.3 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 30.5 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт 69.5 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 65.3 хувийг халамжийн тэтгэврээр, 30.6 хувийг нөхцөлт мөнгөн

тэтгэмжээр, 4.1 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц




ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 9 хүн гэмт хэрэгт холбогдож, 73 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 16, өмчлөх эрхийн эсрэг 45, байгаль хамгаалах журмын эсрэг 1, бусад 11 хэрэг гарсан байна.

Гэмт хэргийн улмаас 6 хүн нас барж, 14 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 214.6 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 8.2 хувийг бүлэглэж 4.0 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 43 хүнийг албадан саатуулж 13 хүнийг баривчилсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 1 сарын байдлаар



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 52.1 хувиар буюу 25 тохиолдлоор өссөнөөс хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 5.3 дахин буюу 13 тохиолдлоор, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 95.6 хувиар буюу 22 тохиолдлоор өссөн байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 1 сарын байдлаар






ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2019 оны 1 сард аймгийн төсөвт 1697.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 1836.9 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 108.2 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 544.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 683.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 125.0 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг бүх сумд 159.0 хувиас 3.6 дахин биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар




Орлогыг нэр төрлөөр нь үзвэл үл хөдлөх хөрөнгийн татвар, хог хаягдалын үйлчилгээний хураамж, төсөвт байгууллагын өөрийн орлогоос бусад нэрийн орлогуудыг 100.0 хувиас 5.3 дахин биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын 62.8 хувийг тусламжийн орлогоор, 29.4 хувийг орлогын албан татвараар, 1.1 хувийг өмчийн татвараар, 2.6 хувийг бусад албан татвараар, 4.1 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 13.6 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 49.6 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 0.8 сая төгрөг бүгд 64.1 сая төгрөгийг шилжүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 4751.7 сая төгрөг байгаагийн 60.5 хувийг цалин хөлсөнд, 7.3 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 32.2 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 29.4 хувийг орон нутгийн засаг захиргаанд, 59.5 хувийг боловсролын салбарт, 9.7 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.9 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0.5 хувийг хүн амын хөгжил нийгмийн хамгаалалын салбарт зарцууллаа.

Орон нутгийн төсвийн байгууллагын нийт зарлагын бүтэц, хувиар



МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас

зузаатгалаар 3.1 тэрбум төгрөгийг авч 1.4 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 1 сард арилжааны банкууд 6.8 мянган иргэд, аж ахуйн нэгжид 14.4 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 1 сарын байдлаар сая.төг



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 27.8 хувиар, олгосон зээлийн хэмжээ 8.8 хувиар өссөн байна. Харин анхаарал хандуулах зээлийн хэмжээ 39 хувиар буурч, чанаргүй зээлийн хэмжээ 37 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2019 оны 1 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0.7 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 7.5 хувиар өссөн байна.

Өнгөрсөн 2018 оны 12 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 373 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 16.6 хувийнх нь өсч, 78.5 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас элсэн чихэр, гоймон, хиам, үхэр адууны мах, шар будаа, сүү, гэрлийн шил,

шүдний оо, шалны хулдаас зэргийн үнэ 0.1 – 21.4 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 33.5 хувийнх нь буюу 125 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 52.2 хувийнх нь үнэ тогтвортой байна.


Өнгөрсөн оны мөн үеийнхээс бүх төрлийн малын мах, үзэм, давс, хорхой ааруул, тараг, шар тос, бензин шатахуун, цамц, хот хоорондын автобусны тасалбарын үнэ, кабелийн телевизийн хураамж, гүрж ногоон цай, ноосон цамц, унадаг дугуй, сахлын татуурга, хөхний даруулга, жинсэн өмд зэрэг барааны үнэ 0.2 – 80.0 хувиар нэмэгдсэн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

2 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний мал 99.97 хувиар онд орж оны эхний малын 0.03 хувь буюу 1.4 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 9.4 хувийг адуу, 17.0 хувийг үхэр, 39.6 хувийг хонь, 34.0 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



Сумдаас Жаргалант, Ихтамир, Өндөр-улаан, Хангай, Цахир, Эрдэнэмандал сумдад оны эхний малын 0.03 хувийн хорогдол гарсан байна.


2019 онд манай аймаг ойгоос 93.2 мянган м3 галын түлээ, 10.6 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 103.8 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 1 сард 3 мянган м3 галын түлээ, 0.3 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 3.3 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 13.0 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2019 оны эхний 1 сард оны үнээр 661.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 422.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн оныхоос үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн 10.6 хувиар илүү байна. Харин борлуулсан бүтээгдэхүүн 11.3 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт,
бүтэц, хувиар



Нийт үйлдвэрлэлтийн 9.6 хувийг хүнс ундааны, 0.9 хувийг хэвлэлийн, 68.6 хувийг дулааны эрчим хүчний

8.5 хувийг усан хангамж, 3.2 хувийг модон эдлэлийн, 9.0 хувийг гутал хувцасны, 0.2 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна. Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, хэрчсэн гурил, бууз, хүснэгт маягт, монгол гутал, дулаан, гэрийн модон тавилгын үйлдвэрлэл 1.7-269.2 хувиар нэмэгдлээ. Харин түгээсэн цэвэр ус, эсгий шаахай, монгол дээл, савхин гуталны үйлдвэрлэлийн хэмжээ 8.3 – 33.1 хувиар буурсан байна.

Тээврийн байгууллагууд 4.4 мянган зорчигч, 1.3 мянган тонн ачаа тээвэрлэн, 2.0 сая хүн км, 0.4 сая ткм ажил гүйцэтгэн 90.0 сая төгрөгийн орлоготой ажиллаа.

Холбооны байгууллагууд 409 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 24.7 сая төгрөгийн орлоготой байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

1 дүгээр сард агаарын дундаж температур -14.1-оос -22.1 хэм хүйтэн байсан бөгөөд хамгийн их дулаан Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Хайрхан, Батцэнгэл, Төвшрүүлэх сумдад 2.0-ээс 6.0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Чулуут, Хангай, Өндөрүлаан, Өлзийт, Батцэнгэл сумдад -34.0-ээс -35.0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Энэ сард Эрдэнэбулган, Хашаат, Өндөр-улаан сумдын нутгаар 0.4 – 0.7 мм цас орсон байгаа бол бусад сумдын нутгаар хур тунадас ороогүй байна.

Статистикийн хэлтэс
2019.01.14